**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:**
**БНА-2023/112/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугаар сарын 24 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........

3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..........

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..........

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..........

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........

4. Аудитын тайлан..........

4.1 Ерөнхий зүйл ..........

4.2 Материаллаг байдал ..........

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..........

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........

5. Аудитын илрүүлэлт ..........

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..........

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/55

танай ______________ -ны № ______________ -т

БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ,
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ж.БОЛОРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал илрээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломж нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн үндэслэл болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зор[illegible] 55



005020263

арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **66,320,021.84** | **159,048,061.87** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 89,490,454.90 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 89,490,454.90 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 89,490,454.90 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 89,490,454.90 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 397,500.98 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 397,500.98 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66,320,021.84 | 69,160,105.99 |
| **351** | **Түүхий эд материал** | 15,404,595.00 | 20,526,192.48 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 10,924,245.00 | 19,872,492.48 |
| 35130 | Эм боох материал | 4,480,350.00 | 653,700.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 123,049.00 | 00.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 50,792,377.84 | 48,633,913.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,611,392.00 | 3,440,310.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,121,102.39 | 22,548,920.06 |
| 35450 | Барилгын засварын материал | 406,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 9,200.01 | 00.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 22,644,683.44 | 22,644,683.44 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,101,302,848.39** | **3,032,149,322.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,101,302,848.39 | 3,032,149,322.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,081,584,848.39 | 3,012,431,322.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,974,323,350.00 | 2,970,923,350.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -95,230,095.92 | -153,104,924.66 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -4,166,666.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 145,105,792.60 | 165,821,891.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,617,872.07 | -75,097,725.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 131,171,949.87 | 132,364,949.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -43,694,891.93 | -59,613,162.43 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,230,060.00 | 12,230,060.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,832,024.16 | -6,055,030.20 |
| 39217 | Ном | 4,128,580.00 | 4,128,580.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,718,000.00 | 19,718,000.00 |
| 39301 | Програм хангамж | 850,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -850,000.00 | -850,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,718,000.00 | 19,718,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,167,622,870.23** | **3,191,197,384.22** |
| **413** | **Өглөг** | 248,989.22 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 248,989.22 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,167,373,881.01** | **3,191,197,384.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,167,373,881.01 | 3,191,197,384.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 468,392,438.00 | 468,392,438.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 468,392,438.00 | 468,392,438.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,324,783,933.88 | 2,348,607,437.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,324,783,933.88 | 2,324,783,933.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 23,823,503.21 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 374,197,509.13 | 374,197,509.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,167,622,870.23** | **3,191,197,384.22** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,954,341,307.00** | **936,831,677.48** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,274,881,855.00** | **24,378,677.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,274,881,855.00 | 24,378,677.48 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,271,593,530.00 | 17,109,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **165,047,552.00** | **220,841,900.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 514,411,900.00 | 691,611,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,349,852.00 | 37,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,349,852.00 | 37,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 136,697,700.00 | 183,841,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 136,697,700.00 | 183,841,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **705,627,302.33** | **911,261,526.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **705,627,302.33** | **911,261,526.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 673,648,682.72 | 901,574,454.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 365,222,678.14 | 445,218,915.00 |
| 210101 | Үндсэн цалин | 282,383,878.14 | 330,810,153.28 |
| 210102 | Нэмэгдэл | 55,751,100.00 | 71,674,670.72 |
| 210104 | Урамшуулал | 27,087,700.00 | 11,752,379.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 30,981,712.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,798,603.24 | 53,471,801.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,116,533.43 | 36,685,733.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,673,229.00 | 4,292,230.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,921,780.80 | 3,433,781.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 644,278.27 | 822,269.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,442,781.74 | 8,237,785.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 125,183,629.22 | 145,207,160.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,219,913.22 | 8,363,374.58 |
| 210302 | Түлш, халаалт | 118,963,716.00 | 134,713,786.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 2,130,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,537,548.00 | 11,144,336.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,096,750.00 | 2,915,612.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,100,000.00 | 1,266,875.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 72,500.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 293,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 850,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,418,298.00 | 6,668,449.63 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 52,861,851.00 | 131,735,862.70 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,618,950.00 | 5,111,450.00 |
| 210502 | Хоол, хүнс | 51,242,901.00 | 124,472,580.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 2,151,832.70 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,954,900.00 | 4,178,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,954,900.00 | 4,178,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 142,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 142,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 867,900.00 | 7,689,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 130,300.00 | 5,724,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 237,600.00 | 1,965,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 68,079,573.12 | 102,928,578.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 3,612,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,308,100.00 | 2,810,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,771,473.12 | 96,506,478.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,978,619.61 | 9,687,071.90 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,528,010.00 | 5,856,233.70 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 5,856,233.70 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,292,630.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,949,880.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,285,500.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдаад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,830,838.20 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,830,838.20 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,450,609.61 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,450,609.61 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,248,714,004.67** | **25,570,151.23** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,042,950.00 | 1,746,648.02 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,042,950.00 | 1,746,648.02 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,042,950.00 | -1,746,648.02 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,247,671,054.67** | **23,823,503.21** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **679,459,452.00** | **912,453,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **679,459,452.00** | **912,453,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 514,411,900.00 | 691,611,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,349,852.00 | 37,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,349,852.00 | 37,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 136,697,700.00 | 183,841,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 136,697,700.00 | 183,841,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **658,659,452.00** | **813,972,545.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **658,659,452.00** | **813,972,545.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **615,072,782.39** | **782,831,043.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 365,795,740.39 | 445,399,468.54 |
| 210101 | Үндсэн цалин | 282,956,940.39 | 330,990,706.82 |
| 210102 | Нэмэгдэл | 55,751,100.00 | 71,674,670.72 |
| 210104 | Урамшуулал | 27,087,700.00 | 11,752,379.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 30,981,712.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,691,800.00 | 53,688,748.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,833,100.00 | 37,846,773.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,464,700.00 | 4,330,518.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,971,300.00 | 3,433,434.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 493,400.00 | 680,105.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,929,300.00 | 7,397,916.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 135,697,700.00 | 145,456,149.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,982,973.22 | 8,363,374.58 |
| 210302 | Түлш, халаалт | 126,714,726.78 | 133,962,775.22 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 3,130,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,297,700.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,567,400.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,100,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 580,000.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 129,800.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 850,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,070,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 54,864,300.00 | 102,885,901.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,589,300.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,736,600.00 | 102,885,901.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,538,400.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,833,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,833,200.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 142,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 142,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,020,242.00 | 10,239,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 280,242.00 | 5,724,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 4,515,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,730,100.00 | 25,161,275.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 18,384,775.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,730,100.00 | 6,776,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,586,669.61** | **31,141,501.90** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,136,060.00 | 27,310,663.70 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,638,550.00 | 21,454,430.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,292,630.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,949,880.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,255,000.00 | 5,856,233.70 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 3,830,838.20 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,830,838.20 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,450,609.61 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,450,609.61 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,800,000.00** | **98,480,454.90** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,800,000.00** | **8,990,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,800,000.00** | **8,990,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,800,000.00 | 8,990,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,800,000.00 | 8,990,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-20,800,000.00** | **-8,990,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 89,490,454.90 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 89,490,454.90 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 448,674,438.00 | 274,344,647.96 | -49,002,510.40 | 00.00 | 674,016,575.56 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,674,438.00** | **274,344,647.96** | **-49,002,510.40** | **00.00** | 674,016,575.56 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,022,278.46 | 00.00 | 9,022,278.46 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **468,392,438.00** | **374,197,509.13** | **2,324,783,933.88** | **00.00** | 3,167,373,881.01 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **468,392,438.00** | **374,197,509.13** | **2,324,783,933.88** | **00.00** | 3,167,373,881.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **468,392,438.00** | **374,197,509.13** | **2,324,783,933.88** | **00.00** | 3,167,373,881.01 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 23,823,503.21 | 00.00 | 23,823,503.21 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **468,392,438.00** | **374,197,509.13** | **2,348,607,437.09** | **00.00** | 3,191,197,384.22 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 906,641,700.00 | 817,653,756.90 | 88,987,943.1 | 90.18 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 906,641,700.00 | 817,653,756.90 | 88,987,943.1 | 90.18 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 867,029,300.00 | 790,343,093.20 | 76,686,206.8 | 91.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 503,063,400.00 | 443,921,518.54 | 59,141,881.5 | 88.24 |
| 210101 | Үндсэн цалин | 359,990,100.00 | 329,795,215.82 | 30,194,884.2 | 91.61 |
| 210102 | Нэмэгдэл | 101,576,200.00 | 71,392,211.72 | 30,183,988.3 | 70.28 |
| 210104 | Урамшуулал | 10,515,300.00 | 11,752,379.00 | -1,237,079.0 | 111.76 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 30,981,800.00 | 30,981,712.00 | 88.0 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,583,300.00 | 53,688,748.86 | 8,894,551.1 | 85.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,556,500.00 | 37,846,773.74 | 4,709,726.3 | 88.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,006,800.00 | 4,330,518.56 | 676,281.4 | 86.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,005,400.00 | 3,433,434.02 | 571,966.0 | 85.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,001,400.00 | 680,105.58 | 321,294.4 | 67.92 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,013,200.00 | 7,397,916.96 | 2,615,283.0 | 73.88 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 149,286,900.00 | 145,456,149.80 | 3,830,750.2 | 97.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,040,000.00 | 8,363,374.58 | 2,676,625.4 | 75.76 |
| 210302 | Түлш, халаалт | 134,246,900.00 | 133,962,775.22 | 284,124.8 | 99.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,000,000.00 | 3,130,000.00 | 870,000.0 | 78.25 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,077,200.00 | 102,885,901.00 | -3,808,701.0 | 103.84 |
| 210502 | Хоол, хүнс | 99,077,200.00 | 102,885,901.00 | -3,808,701.0 | 103.84 |
| 210604 | Урсгал засвар | -500,000.00 | | -500,000.0 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,206,300.00 | 10,239,500.00 | -5,033,200.0 | 196.68 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 688,700.00 | 5,724,000.00 | -5,035,300.0 | 831.13 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,517,600.00 | 4,515,500.00 | 2,100.0 | 99.95 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,312,200.0 | 34,151,275.0 | 14,160,925.0 | 70.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,535,700.00 | 27,374,775.00 | 14,160,925.0 | 65.91 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,776,500.00 | 6,776,500.00 | 0.0 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,612,400.0 | 27,310,663.7 | 12,301,736.3 | 68.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,612,400.00 | 27,310,663.70 | 12,301,736.3 | 68.94 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 33,739,400.00 | 21,454,430.00 | 12,284,970.0 | 63.59 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,873,000.00 | 5,856,233.70 | 16,766.3 | 99.71 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 906,641,700.00 | 908,622,161.80 | -32,480,461.8 | 103.71 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 692,299,800.00 | 691,611,100.00 | 688,700.0 | 99.90 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 692,299,800.00 | 691,611,100.00 | 688,700.0 | 99.90 |
| 131004 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,000,000.00 | 37,000,000.00 | 0.0 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 183,841,900.00 | 180,011,061.80 | 3,830,838.2 | 97.92 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 89,490,454.90 | 89,490,454.9 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 33.00 | 33.00 | 0.0 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.0 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 | 0.0 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14.00 | 14.00 | 0.0 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **35.00** | **35.00** | 0.0 | 100.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 20.00 | 20.00 | 0.0 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 15.00 | 0.0 | 100.00 |

**2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **5,724,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **5,724,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 5,724,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 5,724,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 5,724,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 5724000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 5,724,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 5,724,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сургуулийн насны хүүхдүүдийг бүрэн хамруулах, багш,ажилчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж чадавхжуулах,мэргэжлийн боловсон хүчнээр хангах сургалтын орчныг хүүхдэд ээлтэй эрүүл,аюулгүй стандартын шаардлагад нийцүүлэн багш,ажилчдын тусламжтайгаар тохижуулах,төсвийг зохих хууль тогтоомжийн дагуу өр,авлага үүсгэхгүй зарцуулах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор хичээл сургалтын үйл ажиллагаа, багш ажиллагсдын тасралтгүй хөгжлийг дэмжих, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг тус тус хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг томилсон;
- БШУС-ын 2022.05.12-ны өдрийн 170 дугаар тушаалын дагуу 5 ажлын хэсгийг байгуулсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ЕБС-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баян-Овоо сумын ЕБС-ийн баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,191,197.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 23,574.5 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 66,320.0 | 159,048.1 | 92,728.0 |
| Мөнгөн хөрөнгө | - | 89,490.5 | 89,490.5 |
| Авлага | - | 397.5 | 397.5 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 66,320.0 | 69,160.1 | 2,840.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,101,302.8 | 3,032,149.3 | (69,153.5) |
| Үндсэн хөрөнгө | 3,312,527.7 | 3,331,036.8 | 18,509.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (211,224.9) | (298,887.5) | (87,662.6) |
| **Нийт хөрөнгө** | 3,167,622.9 | 3,191,197.4 | 23,574.5 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,167,373.9 | 3,191,197.4 | 23,823.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,167,373.9 | 3,191,197.4 | 23,823.5 |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд 89,490.5 мянган төгрөгийн төсвийн зарцуулаагүй төсөв үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Авлага дансны үлдэгдэл оны эхэнд үлдэгдэлгүй байсан бол оны эцэст 397.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,160.1 мянган төгрөг болж өмнөх оноос 2,840.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлан онд төсвийн хөрөнгөөр 145,439.6 мянга, хандив тусламжаар 7,269.0 мянган төгрөг орлого авч 149,868.6 мянган төгрөгийн материалыг зарлагадсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,331.0 мянган төгрөг болж 18,509.1 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 15,916.6 мянган төгрөгийн зөөврийн компьютер, НҮБ-ын төсөл, хөтөлбөрөөр 1,193.0 мянган төгрөгөөр ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, Төсвийн хөрөнгөөр 11,990.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 9/29 тоот тогтоолоор 10,590.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,191,197.4 мянган төгрөг болж 23,823.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр өссөн нь шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 909,851.4 мянган төгрөгийг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2,709.7 мянган төгрөгөөр бууруулж 907,141.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 80312, 81605, 81801, 81806, 81816, 81823, 81834, 81835, 81848, 83603, 80112 арга хэмжээг санхүүжүүлэхээр 907,141.7 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 691,611.1 мянга, орон нутгийн төсвөөс 183,841.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, оны эцэст 89,490.4 мянган төгрөгийн үлдэгдлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 799,496.4 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 107,645.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71802 Ерөнхий боловсрол | 907,141.7 | 799,496.4 | 107,645.3 | 88.1 |
| 2 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 1,807.1 | 1,802.0 | 5.1 | 99.7 |
| 3 | 80312 Сургалт семинар | 903.5 | 350.0 | 553.5 | 38.7 |
| 4 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 2,078.1 | 1,050.0 | 1,028.1 | 50.5 |
| 5 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 33,739.4 | 26,919.8 | 6,819.6 | 79.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 133,277.5 | 122,618.6 | 10,658.9 | 92.0 |
| 7 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 11,990.0 | 11,990.0 | 0 | 100 |
| 8 | 81823 Боловсролын байгууллагын багш | 4,065.9 | 2,494.6 | 1,571.3 | 61.4 |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалт | 420,152.9 | 371,269.7 | 48,883.2 | 88.4 |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 83,596.7 | 63,666.0 | 19,930.7 | 76.2 |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээс | 688.7 | 688.7 | 0 | 100 |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 183,841.9 | 180,011.1 | 3,830.8 | 97.9 |
| | **Нийт дүн** | **907,141.7** | **799,496.4** | **107,645.3** | **88.1** |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 37,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг "Наранмандал Энтерпрайзес"ХХК-аас чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд урамшуулалт цалингийн санхүүжилтийг олгосон байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэзням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баян-Овоо сумын ЕБС-ийн захирал Ж.Болормаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Түмэнжаргал нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 911,261.5 мянган төгрөгөөс 9,112.6 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 6,378.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 913,170.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | 0 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 149 | 0 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 703,073.3 мянган төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 154,826.6 мянган төгрөгийн 20 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 35 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитыг 2022 оны 12-р сард хийсэн болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 7,492.6 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн ба Баян-Овоо сумын ЕБС-ийн даргын 2022.05.30-ны өдрийн 217 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 3 | 7,492.6 | 3 | 7,492.6 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **7,492.6** | **3** | **7,492.6** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар Үдийн цай хөтөлбөрийн зардал 12284.0 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 200.0 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрч, 200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

1. Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд олгосон цалингаас 10 хувийн ХХОАТ суутгаж шилжүүлсэн боловч, гарт олгох дүн дээр нэмж дахин 200.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т заасан “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Илүү олгосон 200.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчаас суутган тооцож төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.2. Зөвлөмж

2. Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй бөгөөд гэрэл цахилгаанд 5,219.1 мянга, цэвэр бохир усны төлбөрт 2,747.2 мянга, халаалтын зардалд 48,027.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Зөрчлийн утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд олгосон цалингаас 10 хувийн ХХОАТ суутгаж шилжүүлсэн боловч, гарт олгох дүн дээр нэмж дахин 200.0 мянган төгрөг олгосон байна. | 1 | 200.0 | 1 | 200.0 | | | | |
| **ДҮН** | **1** | **200.0** | **1** | **200.0** | **0** | **0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | | **0** | **0** | **0** | **0** | **1** | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **1** | **0** |

-oOo-